



2018.12.27-ны одор Нийслэлийн удирдлагууд “Оргоо” амаржих газар, ЭХЭМҮТ-ийн гадна зам, талбайн тохижилтын ажилтай танилцлаа. Тус вйл ажиллагаанд НИТХ-ын дарга С.Амарсайхан, Засаг дарга богоод Улаанбаатар хотын Захирагч С.Батболд, Нийгмийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаа, ЭМЯ-ны Торийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Цогтбаатар, Улаанбаатар хотын еронхий менежер богоод Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантомор, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Томорбаатар болон албаны бусад хувьс оролцлоо.

Нийслэлийн Засаг даргын морийн хотолбор, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас эмнэлгийн байгууллагуудын гадна зам, талбайг иж бүрэн тохижуулах ажлыг 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа билээ. Энэ дагуу 2017 онд Шастины нэрэмжит Улсын гуравдугаар тов эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний тов, Хавдар судлалын үндэсний тов, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн товийн гадна зам, талбайг тохижуулан хвлээлгэж огсон. Тэгвэл энэ онд нийт зургаан эмнэлгийн гадна зам, талбайг иж бүрэн тохижуулах ажил хийгдсэн богоод онгорсон есдүгээр сард “Амгалан” амаржих газар, БЗД-ийн нэгдсэн эмнэлэг, ХУД-ийн эрүүл мэндийн товийн 1 дүгээр амбулаторийн гадна зам, талбайг тохижуулсан юм. Харин оноодор “Оргоо” амаржих газар, ЭХЭМҮТ-ийн гадна зам, талбайг иж бүрэн тохижуулсан ажлаа ийнхүү хвлээлгэж огоод байна. Жилд 12 мянган эх амарждаг, 30 гаруй мянган эмэгтэйчүүдэд эмнэлгийн торолжсон нарийн мэргэжийн тусламж, вйлчилгээ үзүүлдэг нийслэлийн “Оргоо” амаржих газрын хувьд амаржсан эхчүүд болон эмэгтэйчүүдийн тасагт хэвтэн эмчлүүлж буй

овчтонвуд, мон эх, нярайг эргэхээр ирсэн ар гэрийнхэний хувьд гадна талбайн гэрэлтүүлэг, явган хvний зам, ойн тогол бvхий ногоон байгууламж, амралтын сvдрэвч болон 150 авто зогсоол зэргийг шийдэж огсноор ая тухтай орчинд вйлчлvлэх бvрэн боломжтой болсон байна.



Улсын хэмжээнд эх, нярайн болон эмэгтэйчvвдийн торолжсон нарийн мэргэжлийн тусламж, вйлчилгээ vзvүлдэг ЭХЭМҮТ-ийн хувьд жилдээ мон 12 мянган эхийг амаржуулдаг, 1100 гаруй ажиллагсадтай томоохон эмнэлэг. Тус эмнэлгийн 15.900 м2

талбайг асфальтаар хучиж, 157 авто зогсоолыг бий болгосон бөгөөд 2260 м² талбайг явган хvний зам болгон тохижуулжээ. Мөн 2500 м² талбайд ногоон тогол байгуулан нийт 85 ширхэг нарс, 48 ширхэг зооврийн мод суулгасан аж. Хоёр байршилд хvнхдийн тоглоомын талбай гарган тохижуулсан тодийгvй 70 ширхэг гэрэлтvвлэг, 74 хогийн сав, 16 ширхэг сандал бvхий 11 амралтын сvндрэвчтэй болгожээ.

Тvннчлэн эмнэлгийн урд талбайд олон улсын жишигт нийцсэн, яаралтай тvргэн тусламжийн вeд ашиглах нисдэг тэрэгний зогсоолыг байгуулаад байна. Омно нь Гэмтэл согог судлалын vндэсний товийн гадна зам, талбайн тохижилтын ажлын хvрээнд нисдэг тэрэгний зогсоолыг байгуулсан билээ.

Эмнэлгийн байгууллагын гадна зам талбайд гэрэлтvвлэг, явган хvний зам, ойн тогол бvхий ногоон байгууламж, амралтын сvндрэвч болон авто зогсоолыг бий болгож, замын ходолгооний зохион байгуулалтыг шийдвэрлэн орц гарцыг нэмэгдvүлснээр иргэд тvгжрэлгvй, аюулгvй, ая тухтай орчинд эрvүл мэндийн тусламж, vйлчилгээ авах нохцлийг бvрдvүлж байгаа юм.

Эх сурвалж: <http://mn.emg.ub.gov.mn/en/trend-news/1797>